

БАЙГУУЛЛАГАЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛГӨӨНИЙ ДАГУУ 2018 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ

2018.12.31

№	Үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	2018	Биелэлт хувь
1.1	Хуулийн хэрэгжилтийг хангуулах эрх зүйн баримт бичиг, төсөл хөтөлбөр боловсруулахад байгууллагын дүрмээр хүлээсэн эрх үүргийн хүрээнд санал боловсруулж шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангах	Ахмадын орон сууцны сонгон шалгаруулах шинэчилсэн журмыг боловсруулах ажлын хэсэгт орж байгууллагын саналыг тусгуулж А\1227 захирамж гаргуулсан.НЗД-ын А\1090 захирамжаар СХД-ийн 19 хороо 21 хороололд шинээр ашиглалтанд орсон 70 айлын орон сууцыг түрээсийн хэлбэрээр ашиглахаар болгож байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэв. Эрчим хүчний тухай хууль, Зохицуулах зөвлөлийн шийдвэр, НӨХГ-ын даргын А\230 дугаар тушаалын дагуу байгууллагын дүрмээр хүлээгээгүй цэвэр бохир ус, дулааны эрчим хүчээр хангах тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байсныг журамд нийцүүлэн ОСНААУГ-ын ХҮТ-5-д шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.	100
1.2	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэрүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажил үйлчилгээний хэрэгжилтийг хангаж ажиллана.	Иргэдийн оролцоотой амьдрах орчноо сайжруулах жилийн хүрээнд нийт 38 сая төгрөгийн засвар үйлчилгээг 901,902 дугаар байрнуудад хийж оршин суугчдын эрүүл аюулгүй орчин амьдрах нөхцлийг сайжруулсан. Камержуулалт -2 аяны хүрээнд хотхоны 901,902 дугаар байрны гадна хаалгыг домофон систем бүхий цоожтой хаалгаар сольж оршин суугчдад цахим түлхүүр /чип/-тэй болгох арга хэмжээ авч хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэнэмэл хүн орцонд хоноглохоос сэргийлж 2 ширхэг хаалганд 1 сая 67 мянга, домофон цоожинд 1 сая 905 мянган төгрөг нийт 3.137,000 төгрөг зарцуулсан.	100
1.3	Орон сууц түрээслэгчдийн тав тухтай, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах, түүнд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, санхүүжилтийг бий болгох арга хэмжээг зохион байгуулах	Хотхоны 901,902 дугаар байрны гадна хаалгыг домофон систем бүхий цоожтой хаалгаар сольж оршин суугчдад цахим түлхүүр /чип/-тэй болгох арга хэмжээ авч хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэнэмэл хүн орцонд хоноглохоос сэргийлэх арга хэмжээг 2 ширхэг хаалганд 1сая 67 мянга, домофон цоожинд 1 сая 905 мянган төгрөг нийт 3.137,000 төгрөг зарцуулсан. Түр сууршуулах 813 дугаар байрны зүүн талд улиас12ш, гацуур 5ш, хус 4ш, нийт 21 ширхэг моднуудыг “Навчит ой” ХХК-иас тарьц худалдан авч суулган ногоон байгууламжийг шинээр байгуулах ажлыг тус тус зохион байгууллаа.	90

1.4	Хотхоны хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай үйлчилгээ авах үүднээс мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж, хамтын ажиллагааг хөгжүүлэх	"Улаанбаатар лифт" ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу 813, 901, 902 дугаар байрны нийт 8 лифтнүүдэд 2018.03.13-ны өдрийн 10/20/18 дугаартай техникийн магадлал хийлгэж ашиглалт үйлчилгээг хэвийн явуулах нөхцлийг хангуулан ажиллаж байна. Төрийн банкны 100 айл дахь салбартай биллинг үйлчилгээ авах гэрээ байгуулж орон сууцны ашиглалтын төлбөр, түрээсийн төлбөрийг нэг банзаар дамжуулж авах нөхцлийг бүрдүүлсэн.	100
Зорилт -1 хэрэгжилт			97%
2.1	Төрийн захиргаа, удирдлагын манлайлал, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөлт, биелэлт, дотоод ажлын зохион байгуулалтыг хангах	Байгууллагын ажилчдын ажлыг жил хагас жилээр үнэлж дүгнэх ажлын хэсгийг томилгоожуулж, байгууллагын 2018 оны жилийн төлөвлөгөөний биелэлтийг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж санал дүгнэлт гарган НЗДТГ-ын ХШҮХэлэтс, ХЕМ-ийн Аудит, дотоод хяналт шалгалтын хэлтэст тус тус хүргүүлж ажилласан.	90
2.2	Хүний нөөцийн бүртгэл, судалгаа, хөгжил, нийгмийн асуудал, нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.	Хүний нөөцийн бүртгэл, судалгаа, хөгжил, нийгмийн асуудал, нэгдсэн бодлогын бичгийн төсөлийг боловсруулсан.	30
Зорилт -2 хэрэгжилт			60%
3.1	Нийт ажиллагсадтай хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулж ажиллах	2018 онд 4 ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцалж, 7 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилласан	90
3.2	Ажлын байрыг тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, байгууллагын логотой ажлын хувцсаар хангах	2018 онд 24 ажилтанд хөдөлмөр хамгааллын хувцас, багаж зэвсэглэлийг олгож ажилласан.	100

3.3	Ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх мэргэжлийн сургалт дамжаанд суралцуулах	Удирдлагын академтай хамтран “Байгууллагын хөгжил, харилцааны ур чадвар” сэдэвт богино хугацааны 16 цагийн сертификаттай сургалтанд 1 ажилтан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 90 дүгээр тогтоолоор Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг баталсантай холбогдуулан www.ublegal.mn цахим хуудсыг шинэчлэхтэй холбоотой мэдээлэл өгөх сэдэвт сургалтанд 2 ажилтан, Улаанбаатар хотын ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-аас зохион байгуулсан уулзалт зөвлөлгөөнд 1 ажилтан, “Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийг сайжруулах учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх, цахим системд мэдээллээ хэрхэн шивэх, анхаарах асуудлын талаархи” сэдэвт сургалтанд 2 ажилтан, Худалдан авах ажиллагааны газраас цахим систем ашиглалтын тухай сургалтанд 1, ажилтан, нийслэлийн Мэдээллийн технологийн газарт Нийслэлийн шилэн тендерийн бүртгэлийн системийн сургалтанд 1 ажилтанг тус тус сургаж мэдлэг чадварыг сайжруулах арга хэмжээ авч ажиллаа. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, түүний харьяа байгууллагуудаас зохион байгуулсан нийт 13 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 15 ажилтныг хамруулж мэдлэг боловсролыг нь дээшлүүлсэн.	90
3.4	Инженер техникийн ажилчдын аюулгүй ажиллагааг хангаж, мэргэжлийн зааварчилга, зөвлөгөөг тогтмол өгч хэвших	Инженер техникийн ажилчдад өдөр бүр аюулгүй ажиллагааг хангаж, мэргэжлийн зааварчилга, зөвлөгөөг тогтмол өгч гарын үсэг зуруулж баримтжуулж ажилласан.	90
3.5	Ажилчдын дунд соёл урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах	1) Цасны баяр, Засаг даргын нэрэмжит Цом аялуулах, Улаанбаатар марфон зэрэг нэгдсэн арга хэмжээний хүрээнд ажилчдын дунд тэмцээн уралдаан зохион байгуулж, 901 дүгээр байрны гарашийн ариун цэвэрийн өрөөг засч сайжруулан албан өрөө тасалгааг цэцэгжүүлж, ХХАА-ны хувцас хэрэглэлийг шинэчлэх ажлыг зохион байгууллаа. Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хорооны өрхийн эмнэлэгтэй хамтран байгууллагын нийт 24 ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт 2018 оны 11 сарын 2-ны өдөр хамруулж эрүүл мэндийн зөвлөгөө, эмчилгээ хийлгэсэн.	100
Зорилт -3 хэрэгжилт			94%

4.1	Орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтийн эзэмшлийн зам талбайг тохижуулах	Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу “Ахмадын хотхон-1”ОНӨААТҮГазраас 2018 оны 05 дугаар сарын 12-ны өдөр 901,902 дугаар байрны гадна талбайд өмнөх онуудад тарьсан моднуудад арчилгаа хийж модны тогоог сэргээн усалгаа хийж, түр сууршуулах 813 дугаар байрны зүүн талд улиас 12ш, гацуур 5ш, хус 4ш, нийт 21 ширхэг моднуудыг “Навчит ой” ХХК-иас тарьц худалдан авч суулган ногоон байгууламжийг шинээр байгуулах ажлыг тус тус зохион байгууллаа. “Үндэсний мод тарих өдөр”-ийн нэгдсэн арга хэмжээнд тус байгууллагаас 22 ажилтан, мөн 901,902,813-р байруудын оршин суугч нар мод тарих ажилд хамтран идэвхитэй оролцон мод тарихад шаардлагатай элс хайрга суулгацаа 2 тээврийн хэрэгсэл татан авч энэ арга хэмжээнд нийт 1.8 сая төгрөг зарцуулж тохижилтын ажил хийгдсэн.	100
4.2	Орон сууцны гадна дотно орчныг камержуулж, гэмт хэрэг зөрчлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулах	Хотхоны орон сууцны халаалтын насос, цэвэр бохир усны шугам хоолой, цахилгаан щит, дээвэрт засвар үйлчилгээ хийж, түр оршин суух 813 дугаар байранд камерийн хяналтын системийг нэмэгдүүлж ажилласан.	90
4.3	Галын аюулгүй байдлыг хангуулах, галын дохиоллын системийн хэвийн найдвартай ажиллагааг хангуулах.	Хотхоны 901, 902 дугаар байрны айл өрх, авто гараашийн галын дохиоллын системд шалгалт хийж, аваар ослын үед найдвартай ажиллагааг хангуулах, ослын гэрэлтүүлгийг шинэчлэх, авто гараашийн гэрэлтүүлгийг шинэчлэх, галын хорыг цэнэглэх арга хэмжээг зохион байгуулсан. Айл өрхийн галын дохиоллын мэдрэгчийн хэвийн ажиллагааг мэргэжлийн байгууллагаар засварлуулахаар шийдвэрлэсэн.	70
Зорилт -4 хэрэгжилт			86%
5.1	Контракт гэрээ, үр дүнгийн гэрээний дагуу төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийг хангах	Хотхоны оршин суугчдын түрээсийн болон ашиглалтын төлбөрт нийт-518,6 сая төгрөгийн орлого татан төвлөрүүлэхээс 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 383,3 сая төгрөгийг татан төвлөрүүлж, 432,2 бараа, ажил үйлчилгээний зардалд зарцуулж, дагуу бүрдүүлж ажилласан	90
5.2	Хөдөлмөр хамгааллын хувцас, хангалтын үйл ажиллагааг төлөвлөх, техник, технологийг шинэчлэх, нэвтрүүлэх, стандарт, норм, нормативыг хангуулах, багаж зэвсэглэмжийн нөөцийг нэмэгдүүлэх, ажил үүрэг гүйцэтгэх чадавхийг бэхжүүлэх	Хөдөлмөр хамгааллын зуны хувцасны хангалтыг 25 ажилтанд олгож, цэвэрлэгээний хүрз, жоотуу, хувийн багаж зэвсэглэмжийг хугацаанд нь олгож ажиллаа.	90

5.3	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах	Байгууллагын цахим хуудас www.akhmadiinkhotkhon-1.ub.gov.mn сайтад үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тухайд бүр байршуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой арга хэмжээг www.openulaanbaatar.mn сайт дээр байгууллагын санхүүгийн ил тод байдлыг www.shilendans.gov.mn/ цахим хуудсыг хөтлөн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	90
Зорилт -5 хэрэгжилт			90%
6.1	Орон нутгийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж, хяналт шинжилгээ үнэлгээ хийх, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж, тооллого хийх, зөвлөмж өгөх.	Монгол улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 193 тоот тогтоолын дагуу манай “Ахмадын хотхон-1” ОНӨААТҮГазрын эргэлтийн бус хөрөнгө болох газар, барилга байгууламжийн дахин үнэлгээг санхүүгийн тайлагналын зориулалтаар, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэн гэрээний дагуу “Акпар” аудитын компанид хүлээлгэн өгсө.	90
Зорилт -6 хэрэгжилт			90
Стратеги төлөвлөгөөний биелэлт			86

ХЯНАСАН:
ДУЛААНЫ ИНЖЕНЕР

Г.ЧУЛУУНБААТАР

ТӨЛӨВЛӨСӨН:
ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

Г.БААТАРХҮҮ